

## **БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд аймгийн эдийн засаг, нийгмийн салбарт үндэсний 78 хөтөлбөр, нэг төсөл хэрэгжүүлэхээр бүртгэл хяналтанд авч ажилласан байна.

Үндэсний хэмжээний хөтөлбөр төслийг хэрэгжүүлэхдээ дараахь арга барилаар ажилласан байна. Үүнд:

1. Үндэсний хэмжээний томоохон хөтөлбөрүүдийн үндсэн зорилт, заалтуудыг аймгийн 2010-2020 оны хөгжлийн хөтөлбөрт тусгасан.

2. Аймаг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар заалт оруулсан.

3. Аймаг, сум, байгууллагын жилийн болон хэтийн стратеги, бизнес төлөвлөгөөнд үндэсний хөтөлбөрүүдийн зорилт заалтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

4. Зарим томоохон хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүд боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлж хэрэгжүүлэх ажил зохион байгуулсан

5. Аймгийн Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгэм хамгаалал, хүнс хөдөө аж ахуйн салбар жил бүр ажилтан, мэргэжилтнүүдийн аймгийн зөвлөлгөөн хийж, үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц байдлын талаар хэлэлцдэг уламжлалтай болсон.

### **I. Боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийн талаар**

Боловсролын салбарт 5 хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаас биелэлтийн явц нь 50-70 хувьтай байна. Эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд 2009 онд 29,8 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн дотроос англи хэл, бичиг үсгийн боловсролын болон зайны сургалтын үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт, үр дүн харьцангуй сайн байна гэж үзлээ. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх сумдын гэгээрлийн төв болон аймгийн Боловсрол, соёлын газрын дэргэд бичиг үсгийн сургалт тогтмол явагддаг болж жилд дунджаар 290-330 хүүхдэд боловсрол нөхөн олгож байна.

Мөн сумдад зайны сургалтын бичил төвүүд байгуулагдан ажиллаж байна. Мөн сургууль бүрт англи хэлний 2-3 кабинеттэй болж мэргэжлийн багшаар хангагдсан байна.

Боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа “Монгол улсын Шинжлэх ухаан технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт, үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, санхүүгийн эх үүсвэргүй байна.

### **II. Соёлын салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний Хөтөлбөрүүдийн биелэлтийн талаар**

Соёлын салбарт 5 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба биелэлтийн явц нь 30-70 хувьтай байна. Эдгээр төслийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 9,9 төгрөг зарцуулсан байна..

Соёлын салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд түүх соёлын дурсгалын зурагт альбомтой болсны дээр Өлгий хот дахь Монгол угсаатны соёлын төвийг түшиглэн морин хуур, баруун монголын уламжлалт бий биелгээний сургалт зохион байгуулж нийт 100 гаруй хүүхдэд морин хуур тоглох, уламжлалт бий биелгээ хийх анхан шатны мэдлэг олгосон байна.

### III. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийн талаар

Эрүүл мэндийн салбарт 12 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт нь 30-90 хувьтай байна.

Эрүүл мэндийн салбарт үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд нийт 12,5 сая төгрөг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн салбарт үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь бодит ажлуудыг зохион байгуулж хийсэн байна.

1. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн кабинетийг тохижуулан ДЗОУБ-ын санхүүжилтээр тоног төхөөрөмжөөр хангасан. Дээрх байгууллагын тусламжаар 38 сая төгрөгийн 9 нэр төрлийн, 83 сая төгрөгийн 10 нэр төрлийн тоног төхөөрөмж олгогдсон.

2. Ногооннуур сум 7,6 сая төгрөгөөр иж бүрэн спортын хэрэгслээр хангагдсан, цогц загвар кабинет байгуулсан ба Алтай, Буянт сумдын, Хөххөтөл Бастама сургуулиудад спорт заал баригдаж, сургууль бүр дунджаар төсвөөс 1,2-1,3 сая төгрөгөөр спортын хэрэгсэл авсан болно. Өлгий хотод 2010 онд 1,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй спорт цогцолбор ашиглалтанд орно.

3. Эхчүүдийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвөөс 4,0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгож, эмзэг бүлгийн эхчүүдийг Улаанбаатар хотод эмчлүүлэх зардлыг олгосон. Загвар сум болон Булган, Цэнгэл сумдын сургуулийн хүүхдүүдэд сургалт зохион явуулж, 2 их эмчийг Улаанбаатар хотод сургалтад хамруулав. Бүх сумдад болон багийн бага эмч нарт ЭХО оношлогооны бүсчилсэн сургалт зохион байгуулав. Мөн тус хөтөлбөрийн дагуу 2 сумдын эмнэлгүүдийг тохижуулж, аймгийн төвийн Ахлах 3 дугаар сургуулийн эрүүл мэндийн кабинетийг тоног төхөөрөмжөөр хангасан.

4. Аймгийн дэд хөтөлбөр батлуулж, түүний дагуу ажиллав. Үүнд ХӨСҮ төвөөс нөөц вакцин био бэлдмэлийг 8 удаа хүлээн авч, зохих журмын дагуу нөөцөлж, хэрэгцээтэй газруудад тараасан. Дархлаажуулалтын төвийн хөрөнгө оруулалтаар сум, өрхийн эмнэлгүүдийг шаардлагатай материалаар хангаж ажиллав.

5. Усны газартай хамтран 47 рашааны тооллогыг аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн яамны тусгай зөвшөөрлөөр Ак-су рашаан сувилал үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 80 хүнийг хүлээн авах хүчин чадалтай, тохилог орчин бүрдүүлсэн. Мөн Эрүүл мэндийн яаманд асуудал тавьж 2010 онд рашаан сувилалд 80 ор авахаар төсөвт тусгасан.

6. 2009 онд нийт 366,0 мянган төгрөг зарцуулж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Үүнд бүх сумдад 2 хоногоор бүх чиглэлээр эмч нар очиж 4 төрлийн шинжилгээний аппаратаар оношлогоо, эмчилгээ хийж зөвлөгөө өгөв.

7. Иод дутлын эмгэгийн тархалтын байдалд сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаа байхгүй, айл өрхийн иоджуулсан давсны хэрэглээний талаархи мэдлэг сайжирсан. 2008 оны жилийн эцсийн 11664 өрх иоджуулсан давс хэрэглэж байна.

8. 2009 онд нийт 8 суманд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг хийж 3000 хүүхэд хамруулсны 73 хувь нь шүд, амны хөндийн өвчлөлтэй байсан. Мөн цэцэрлэгийн 40 хүүхдэд шүд цоорох өвчнийг зогсоож, хүндрэлээс урьдчилан сэргийлэх мөнгөлөг түрхлэг хийлгэв. Дэлхийн Зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр шүдний кабинетийг багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Нийт 468500 төгрөг зарцуулагдсан.

9. Орчны эрүүл мэндийн талаар эмнэлгийн эрхлэгч нарт сургалт хийж, эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах талаар заавар зөвлөмжөөр хангасан. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Өлгий сумын ЗДТГ, Эрүүл мэндийн газартай хамтран баг, албан байгууллагуудын орчны эрүүл ахуйн байдалд хяналт тавьж, эзэнгүй хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ авсан.

10. Эхний үе шат дуусч, шинээр батлагдсан хөтөлбөрийг холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан. Дэд хөтөлбөр боловсруулах, төлөвлөгөө зохиох ажлууд хийгдэж байна.

11. Сэтгэцийн эрүүл мэнд-2 хөтөлбөрийг холбогдох хүмүүстэй танилцуулж, аймгийн дэд хөтөлбөр боловсруулж байгаа.

#### IV. Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийн талаар

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр 7 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрээс 2009 онд хийхээр төлөвлөсөн ажлууд 70-90 хувийн биелэлттэй байна. Энэ оны байдлаар уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 17,7 төгрөг зарцуулсан байна.

2009 онд дараахь ажлуудыг зохион байгуулж хийсэн байна. Үүнд:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлаж, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Монголын Залуучуудын холбооны аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Залуучуудын холбоо, Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байна. 2009 онд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1500 оюутан суралцаж байна. Мөн шинээр хүүхэд, залуучуудын өргөө барих төсөл боловсруулан хэрэгжүүлэхээр бэлдэж байна. Тогтоосон хугацаанд тайланг явуулж байгаа. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг 5,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Цагдаагийн хэлтэст хүүхдүүдээс мэдүүлэг авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх танхимыг Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр шинээр байгуулан ажиллуулж байна.

2. Эмэгтэйчүүдийн ТББ-тай хамтран 2009 онд 4 удаа сургалт зохион байгуулсан.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн зөвлөлгөөн зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 1254 иргэнд түлээ нүүрсний хөнгөлөлт, нүдний шил, шүд, ортопед, протезийн үйлчилгээнд 139 сая төгрөг зарцуулсан. Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй 97 иргэний нэг талын зардалд 18,5 сая төгрөг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийг нээн ажиллуулж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах ТББ-тай холбоотой ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай санд 2100,0 сая төгрөг төвлөрүүлсэн. ХБИ-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, хөнгөлөлт тусламжинд 1254 иргэн, байнгын асаргаанд 592 иргэнийг хамруулан 116,752,0 мянган төгрөг зарцуулсан. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 50 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, 35 иргэн байнгын ажлын байраар хангагдсан.

4. Аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 48 тоот тушаалын дагуу Хүүхдийн төлөө төв, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёлын газартай хамтран 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөл боловсруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Хүүхдийн сэхээний тасагт ДЗОУ байгууллагын тусламжаар 11,0 мянган долларын аппарат тоног төхөөрөмжөөр хангасан.

5. 2009 онд шинээр ажлын байр бий болгох ажлын хүрээнд 1520 шинэ ажлын байр бий болсон. Хөдөлмөр эрхлээгүй хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдэд зөвлөгөө өгч, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулан, 137 иргэнд 132 сая төгрөгийн зээл олгож, шинээр ажлын байр бий болгосон 165 иргэнд зээлийн хүүгийн нөхөн төлбөрт 14 сая төгрөг олгосон. Зам засах ажлын хүрээнд 6 сумдын 145 км урт бартаатай замын ажлыг гараар засч тохижуулах, 7 сумдын 181 га хадлангийн талбайг усжуулах, хот тохижуулах ажилд 120,7 сая төгрөг зарцуулж, эмзэг бүлгийн иргэдийг түр ажлын байраар хангаж ажилласан.

6. Ажлын байранд тавигдах шаардлагыг Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжилзүйн төв, ХХААЖДҮ-ийн газар зэрэг мэргэжлийн байгууллагуудаас холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулж, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлээд байна. Аттестатчиллын журам боловсруулагдаж 11 сард аттестатчилал явагдсан.

#### V. Хууль зүйн чиглэлээр хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Хууль зүйн чиглэлээр 9 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба 2009 онд хийхээр төлөвлөсөн ажлуудын 50-90 хувийн биелэлттэй байна. Энэ арга хэмжээнд 7,2 сая төгрөг зарцуулсан байна.

1. Согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар санамж, гарын авлага плакатуудыг сум, өрхийн эмнэлгүүдээр дамжуулан тараасан.

Эрүүлжүүлэх байранд 7 хоногт нэг удаа мэргэжлийн эмч нар очиж, эрүүлжүүлэгдсэн хүмүүст зөвлөгөө өгч ажиллаж байна. Хоёр суманд очиж өсвөр насны 60 хүүхдүүдийг хамруулж, архи тамхины хор нөлөөний тухай семинар зохион байгуулсан.

2. Хүний эрхийг хангах механизмыг бэхжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр байгууллагын төлөөллийг аймгийн ИТХ-ын даргын саналаар ТББ-дын зөвлөлийг шинээр байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын зөвлөлд ард иргэдийн трөлөөлөгчөөр аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн даргыг оруулсан. Рамазан сар, хурманайтын үеэр 1150,0 сая төгрөгийн хөрөнгийг Турк улсын хөрөнгө оруулалтаар 10,000 хонь, 17000 ямаа, 3000 үхэр нядалж ядуу зүдүү хүмүүст тусламж үзүүлсэн. Сургууль завсардсан хүүхдүүдийг албан бус боловсрол олгох сургалтад хамруулан зохих шатны боловсролыг олгож байна.

3. 2009 онд ЗЦА-ыг 1 суудлын автомашиэ, 3 мотоцикль, 4 гар станц, 3 согтуурлыг шалгах техник хэрэгслээр хангасан. ТЗА, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтарч нийт 26 арга хэмжээ зохион явуулав. Мөн Цагдаагийн бусад албадтай хамтарч 10 удаа нээлттэй өдөрлөг хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сануулга сурталчилгаа явуулсан. ЦЕГ-аас зохион байгуулсан бүсчилсэн сургалтад тасгийн албан хаагч нарыг оролцуулав. Замын цагдаагийн тасгийн байцаагч, зохицуулагч нар давхардсан тоогоор 15920 тээврийн хэрэгслийг шалгаж, 15623 зөрчил илрүүлж, зөрчилтэй 675 тээврийн хэрэгслийг түр саатуулан зөрчлийг нь арилгуулж, 4732 хүнийг 12 сая 841 мянган төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 215 хүнийг илрүүлж, 150 хүний жолоодох эрхийг хасч, 65 хүнийг шүүхэд шилжүүлсэн. Өлгий сумын төвийн 40 гэрлийн шонг засварлан, 136 гэрлийн шонг шинээр тавьсан. Төвийн гудамжуудад 2009 онд 137 ширхэг гэрэлтүүлэг нэмж тавьсан. Тогтвортой амьжиргаа-2 төслийн шугамаар Өлгий хотын төвд 1,4 км явган хүний зам тавигдсан.

4. Хүний нөөцийн мэдээллийн системд бүх төрлийн төрийн албан хаагчийн бүртгэл, төрийн сангийн үйл ажиллагааг онлайн системд холбосон. Архивын ерөнхий газраас "ORG-AMS" архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг аймгийн ИТХ-ын чуулганд оруулан, 2010 онд авахаар ажил зохион байгуулж байна. 2009 онд 6 байгууллагын 750 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлт хийж, сан хөмрөгийн 8500 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын хайрцагтай болгов. Архивын албад хамгаалалтын дохиоллын систем байрлуулсан.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг холбогдох байгууллага, мэргэжлийн ажилтнуудад үүрэг болгож, аймгийн радиогоор өгөв. Аймгийн хэмжээгээр судалгаа гаргахыг шат шатандаа хийлгэв. Одоогоор худалдагдсан хүүхэд гараагүй.

6. 2009 онд нийт 1100 хүнд эрх зүйн зөвлөгөө өгч, 9 удаа 16 сэдвээр албан бус сургалтад 156 иргэдийг хамруулав.

Төлбөрийн чадваргүй 698 хүний 4689 хуудас бичиг баримтыг канондож өгч туслав. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1426,3 мянган төгрөг зарцуулсан.

7. Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлаж, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Монголын Залуучуудын холбооны аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Залуучуудын холбоо, Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байна. 2009 онд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1500 оюутан суралцаж байна. Мөн шинээр хүүхэд, залуучуудын өргөө барих төсөл боловсруулан хэрэгжүүлэхээр бэлдэж байна.

8. Монгол улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж хариуцсан ажлын чиглэлээр хэлтэс, албад зохион байгуулж хугацаанд нь хэрэгжүүлэн үр дүнг салбарын чиглэлээр тооцон ажиллаж байна. (ИБМА, төрийн өмч, ТИХАЭС газар, татвар гэх зэрэгт тусгагдсан чиглэлээр) Одоо манай аймаг хүн амын бүртгэл мэдээллийн шинэчийлсэн бүртгэлтэй болсон.

#### ҮІ. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт 12 хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаас 2009 онд хэрэгжилт нь 50-90 хувьтай, зарцуулсан хөрөнгө 42,2 төгрөг зарцуулсан байна.

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлыг жил бүрийн төсөвт тусган, аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд нэг үзүүлэлт болгон тусгасан. 2009 онд ХӨУСАХ-ний зардалд 260,0 сая төгрөг тусгаж, сумдын ЗДТГ-аар дамжуулан санхүүжилт олгосон. Сумдын захиалгын дагуу 22 төрлийн 501,0 сая төгрөгийн эмийг төвөөс

татан авч, мал эмнэлгийн нэгжүүдийн захиалгаар хуваарилан олгож хийлгэсэн болно. 2009 онд аймгийн Засаг даргын 164 тоот захирамжийн дагуу бүх сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний чанарт аттестатчлал явуулсан.

2. Үндэсний хатгамал оёмол бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үүднээс “Алтай Керей крафт” ХК-д 120,0 сая төгрөгийн зээл олгож, 6 сумдад оёдлын цех нээж ажиллуулсан. Энэ онд ЖДҮ-ийн сангаас 84 аж ахуйн нэгж, хувь хүнд 741,5 сая төгрөгийн зээл олгосон. Ховд аймагт болсон “Баруун бүсийн түншлэл-2009” үзэсгэлэн худалдаанд оролцож “Аватекс-Хайнар” ХХК-ийн угаасан ноос экспортын шилдэг бүтээгдэхүүнээр “Алтай Керей крафт” ХК-ийн хатгамал бүтээгдэхүүн шилдгийн шилдэг бүтээгдэхүүн цомоор, бусад аж ахуйн нэгжүүд алт, мөнгө, хүрэл медалиар шагнагдав.

3. Эрчимжсэн аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өмнө нь байсан сүүний чиглэлийн фермерүүдийн үнээг өндөр ашиг шимт бухын гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэг хийсэн. 2010 онд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд 3,6 сая төгрөг орон нутгийн төсөвт тусгуулахаар оруулсан боловч, хөрөнгийн эх үүсвэргүйгээс батлагдаагүй.

4. Ногоон хувьсгал хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Өрхийн тариалан эрхэлдэг өрхийн тоо нэмэгдэж 4000 гаруй өрх, өрхийн тариалан эрхэлдэг болсон.

5. Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажилласан. Шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж, 2010 оны төсөвт тусгуулах саналыг оруулсан.

6. Малын чанар сайжруулах дэд хөтөлбөр боловсруулж ИТХ-аар батлуулсан. Аймгийн малчдын зөвлөлгөөн хийж, энэ асуудлыг хэлэлцүүлж уриалга гаргасан. Аймгийн төв болон Баяннуур сумын 95 үнээнд сайн үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийгдсэн. Сүүний үүлдрийн ухнын үрээр зохиомол хээлтүүлэг хийхээр 50 ямааг тусгайлан суурилж бэлтгэл ажил хийгдээд байна. Хөтөлбөрт зориулж орон нутгийн төсөвт тусгасан хөрөнгө байхгүй. 2008-2009 онд 10-15 үнээтэй сүүний чиглэлийн 5 мини фермер байгуулагдсан. ХХААХҮ-ийн яамнаас 4 фермерт тус бүр 5 үнээ өгөхөөр шийдвэрлэж эхний 2 фермерт 10 үнээ өгөгдсөн үйл ажиллагаагаа явуулж байна.

7. Малын тэжээл дэд хөтөлбөрийг ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсан. 2010 оны төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 22 сая төгрөгийн төсөв оруулсан боловч, төсвийн боломжгүйгээс батлагдаагүй. Газар тариалан эрхэлдэг, тэжээл бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдэд сүүлийн 2 жилд 18 ширхэг бага оврын трактор дагалдах хэрэгслийн хамт 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон.

8. “Атрын гурав дахь аян” хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны 17 хувийг, төмсний 70 хувийг өөрийн үйлдвэрээр бүрэн хангаж байна. Сум бүрт зоорь хүлэмж бүхий агропарк байгуулсан. Тариаланд тохиромжтой Бугат, Баяннуур, Ногооннуур, Алтанцөгц, Сагсай сумдын талбайг газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд эзэмшүүлсэн.

9. Аймагт 14 агропарк байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. 14 ширхэг хүлэмж барьж 645 кг нарийн ногоо хураасан. 305 тоннын багтаамжтай 14 ширхэг зоорь барьсан. Аймгийн тариаланчдын холбоо, ХААН нэвтрүүлэх төвтэй хамтран сургалт явуулж байна.

10. “Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр-2”-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулж, 153 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2010 онд төсөвт тусгуулахаар 12,5 сая төгрөг төлөвлөж оруулсан боловч, төсвийн боломжгүйгээс батлагдаагүй.

## ҮII. Аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Энэ салбарт 11 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас биелэлт нь 50-90 хувьтай байна. Эдгээр салбарт хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 1,9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

1. Ноос, ноолуур, арьс ширний жижиг үйлдвэр байгуулах чиглэлээр Буянт сумын эсгий боловсруулах Жол жамсы ХХК нийт 700 ширхэг буюу 5601 метр квт эсгий боловсруулсан байна.

2. Аймгийн Засаг даргын 2009 оны 248 тоот захирамжаар ЖДҮ-ийг дэмжих аймгийн комисс 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор 83 аж ахуйн нэгж, иргэнд 763,0 сая төгрөгийн зээл олгосон ба үйл ажиллагаанд нь хяналт тавин

ажиллаж байна. Мөн ЖДҮ эрхлэгчдэд ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн нь байнга зөвлөгөө өгч байна.

3. Үйлдвэржүүлэх хөтөлбөрийн үндсэн зорилтуудыг аймгийн хөгжлийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009, 2010 оны үндсэн чиглэлд тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж байна.

4. Бичил уурхайн хэлбэрээр олборлож болох орд илэрлийг Ногооннуур, Цэнгэл, Булган сумдын хэмжээнд гаргаж, бүрдүүлэх материалын талаар сумдын Засаг дарга, газрын даамал болон байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт танилцуулан, хоршоо хэлбэрээр зохион байгуулж ажиллуулах судалгаа гаргаж ажиллаж байна.

5. 40 айлын орон сууц ашиглалтад бүрэн орсон. 20 айлын орон сууцны барилгын угсралтын ажлын 4 давхарын угсралтыг бүрэн дуусгасан. 5 давхарын ханын өрлөгийн хучилтаас бусад ажлыг 2010 онд дуусган ашиглалтад оруулна.

6. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өлгий хотын гэр хорооллуудыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах цэвэр, бохир усны шугамын өргөтгөл хийж орон нутгийн засаглалыг дэмжих сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр 8 дугаар багт 1 км 200 метр урт цэвэр усны шугам тавигдсан. Хэсэгчлэн 2009 онд 197 у/м шугам 40 айлын гадна хийгдсэн.

### ҮIII. Байгаль орчны салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Байгаль орчны салбарт 17 хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаас биелэлт нь 50-90 хувьтай, зарцуулсан хөрөнгө 33,7 сая төгрөг байна.

1. Цаг агаарын аюултай болон онц аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээг тухай бүр холбогдох газар, аймгийн радио, сумдын багийн холбоо VSAT, Жи Мобайл зэрэг хөдөлгөөнт холбоонуудаар өгдөг. Жил бүр 12, 2 дугаар саруудад нийт багийн нутгаар цасны хээрийн хэмжилт, 6, 8 дугаар саруудад бэлчээрийн ургацын хэмжээ тогтоож өвөлжилтийн байдлыг үнэлдэг.

2. Өлгий хотын төвийн хатуу хог хаягдлын цэгийг эмхлэх талаар хот тохижуулах албатай хамтран арга хэмжээ авч ажиллаж байна. Хөдөө сумдын хувьтд тухайн сумын байгаль хамгаалагч болон сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж байгаа болно.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө болон ард иргэдийн оролцоотой удаан задардаг органик бохирдуулагч бүхий 441 тонн хог хаягдлыг ачин зайлуулж хогийн цэгт хүргэж овоолго үүсгэн булалт хийв.

4. Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хуулийн хүрээнд хяналт тавин ажиллаж байна.

5. 2009 онд газар хөдлөлтийн шинэ станцын байрыг 13,0 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан. Газар хөдлөлтийн мэдээг дамжуулах GADE боловсруулалтын программыг нэвтрүүлсэн. Станцын ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

6. Ус, цаг уурын үзүүлэлтүүдээр олон жилийн судалгаа гаргаж уур амьсгалын өөрчлөлтийн талаар эрдэм шинжилгээний ажил буюу илтгэл бичиж хэлэлцдэг.

Аливаа хурал цуглаанд уур амьсгалын өөрчлөлтийн талаар байнга танилцуулдаг. Японы эрдэмтэдтэй хамтран Алтай Таван Богд уулсын Потанины мөсөн гол, Цамбагарав ууланд мөстлийн хайлалтын судалгааг 2003 оноос хийж байна.

7. Үүлэнд зориудаар нөлөөлөх тоног төхөөрөмжтэй болж түүнийг ажиллуулах мэргэжилтнийг сургаж дадлагажуулсан.

8. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өлгий хотын гэр хорооллуудыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах цэвэр, бохир усны шугамын өргөтгөл хийж орон нутгийн засаглалыг дэмжих сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр 8 дугаар багт 1 км 200 метр урт цэвэр усны шугам тавигдсан. 2006-2009 онуудад улсын төсвийн хөрөнгөөр 49 худаг шинээр гаргаж, 43 худагт засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн. Хуучин услалтын системийн барилга байгууламжуудыг засварлах, шинээр усалгааны суваг шуудуу татах ажил эрчимтэй хийгдэж байна. 2009 онд Булган сумын Цагаан-Эрэгт 100 га, Улаанхус сумын Жаланашт 200 га, Цэнгэл сумын Хартатарт 200 га талбайд улсын төсвийн болон аж ахуйн нэгжүүдийн 40:60 хувийн харьцаатай хөрөнгөөр услалтын систем баригдаж ашиглалтанд орсон.

9. Сармисан сонгиныг хамгаалах тарималжуулах туршилт хийгдсэн цаашид нутгийн иргэдэд түшиглэн хамгаалж тарималжуулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

10. Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд 2009 онд Өлгий сумын Хар үзүүр гэдэг газар 5 га-д ойжуулалт хийгдсэн мөн сүүлийн 5 жилд 61 га-д ойн туслах зурвас байгуулах ажил хийгдсэн. 2009 онд хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд ХХҮХ-тэй хамтран 15 хүнийг ажлын байраар хангасан. Шар шавраар блок үйлдвэрлэн малын болон айл өрхийн хашаа барихад ашиглаж байгаа ба чулууг өргөнөөр ашиглаж аймгийн хэмжээний айл өрхүүдийн 90 орчим хувь нь уг аргаар хашаа хороо барин, мод хэрэглэх асуудал бүрэн зогссон гэж үзэж болно.

Малчдын бүлэг байгуулан зарим сумдад бэлчээрийг хуваарьтай ээлж дараатай ашиглаж эхэлж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой газар нутгийг хамгаалан хариуцуулахад ААН 4, Хамтлаг 1, ТББ 1, айл өрх-1, иргэн 46 хамруулан ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд жил бүр 5 дугаар сарын 1-ээс 10-ны хооронд мод тарих 10 хоногийн ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж жил бүр 10-30 мянган ширхэг мод суулгаж хэвшсэн байгаа.

Ойжуулалтын ажил хийхэд жил бүр хөдөлмөр эрхлээгүй 15-20 хүнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.

Үр тарьц суулгац борлуулах зорилгоор Өлгий суманд 10 га газарт мод үржүүлгийн талбай байгуулан одоогийн байдлаар 66,0 мянган ширхэг мод суулгац ургуулж байна. Байгаль орчны мэдээллийн төвийг уг газрын конторын барилгын хамт ашиглалтанд оруулж Алтай Соёны биологийн төрөл зүйлийг хамгаалах төслийн газартай хамтран иж бүрэн тохижуулах ажил хийгдэж байна.

## **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

/2009 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтад авсан заалт		Хэрэгжилтийн явц	
			Нийт хэрэгжүүлэх заалт	Аймагт хэрэгжих	Тухайн жилд хийсэн ажлын явц (хувь)	Хөтөлбөр, төсөл хэрэгсэнэ эс хойш хийсэн ажлын явц (хувь)
<b>Боловсрол</b>						
1	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр 2004-12-22 Дугаар 244	2004-2012	4	4	90%	90%
2	Зайны сургалтын үндэсний хөтөлбөр 2002-01-25 Дугаар 14	2002-2010	5	5	90%	90%
3	СӨБ болон Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх ҮХ 2008-08-13 Дугаар 316	2009-2015	12	5	90%	90%
4	Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр 2008-07-16 Дугаар 293	2008-2020	3	2	50%	70%
5	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2 2008 Дугаар 196	2008-2015	4	4	90%	70%
6	МУ-ын ШУ, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх ҮХ 2000 Дугаар 202	2001-2010	2	2	70%	70%
<b>Соёл</b>						
7	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр 1997 №255	1997-2030	5	5	90%	70%
8	"Монгол хөмий" ҮХ 2007-06-26 Дугаар 159	2008-2014	4	4	70%	70%
9	"Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалах, сэргээн засварлах" хөтөлбөр 2007-11-21 Дугаар 303	2008-2015	11	9	90%	90%

10	" Морин хуур, уртын дуу" ҮХ 2005-03-09 Дугаар 43	2005-2014	4	4	90%	90%
11	Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөр 2009-01-14 Дугаар 10	2009-2014	3	3	70%	70%
<b>Эрүүл мэнд</b>						
12	Эрүүл мэндийн технологийг сайжруулах ҮХ 2002 Дугаар 264	2002-2010	2	2	90%	70%
13	Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх хөтөлбөр 2002 Дугаар 139	2002-2013	4	4	90%	90%
14	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр 2007-06-20 Дугаар 150	2007-2012	6	6	90%	90%
15	Нөхөн үржэхүйн эрүүл мэнд ҮХ 2007-03-07 Дугаар 52	2007-2011	6	6	90%	90%
16	Халдварт өвчинтэй тэмцэх ҮХ 28.06.2002 Дугаар 129	2002-2010	4	4	90%	90%
17	Рашаан сувиллыг хөгжүүлэх ҮХ 2002-12-13 Дугаар 251	2003-2010	4	4	90%	90%
18	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах ҮХ 2005-12-14 Дугаар 246	2006-2009 2010-2013	3	3	90%	90%
19	"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" 3 хөтөлбөр 2007-04-04 Дугаар 85	2007-2011	4	3	90%	90%
20	Амны хөндийн эрүүл мэнд ҮХ 2006-06-28 Дугаар 150	2006-2010 2011-2015	3	3	90%	90%
21	Орчны Эрүүл мэнд ҮХ 2005-12-30 Дугаар 245	2006-2015	4	3	90%	90%
22	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр 09.09.2009 Дугаар 279	2010-2012 2013-2016	3	3	50%	30%
23	Сэтгэцийн эрүүл мэнд ҮХ-2 2009-09-30 Дугаар 303	2010-2014 2015-2019	5	5	50%	30%
<b>Нийгмийн халамж</b>						
24	Өсвөр үе, хүүхэд залуучуудыг дэмжих үндэсний хөтөлбөр 2006-11-21 Дугаар 282	2007-2008 2009-2012 2013-2015	24	20	90%	90%
25	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2002-12-30 Дугаар 274	2009-2012 2013-2015	15	15	90%	90%
26	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр 2006-11-21 Дугаар 283	2006-2008 2009-2012	6	6	90%	90%
27	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр 2008 Дугаар 284	2006-2015	18	17	90%	90%
<b>Хөдөлмөр</b>						
28	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2006-2010	2	2	90%	70%

	үндэсний хөтөлбөр 2002-05-15 №92					
29	Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр 2005-04-13 №75	2007-2010	6	5	70%	90%
<b>Хууль зүй</b>						
30	Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр 2003-11-20 №48	2003-2007 2008-2012	5	5	90%	90%
31	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2002 №41	2002-2005 2006-2010	3	3	70%	90%
32	Монгол Улсад Хүний эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр 2009-03-11 №69	2009-2010	6	4	90%	90%
33	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр 2006-12-27 №315	2007-2010	8	6	90%	90%
34	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр 2006-04-03 №64	2006-2008 2009-2012	8	8	70%	70%
35	Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр 2005-11-30 № 234	2008-2011 2011-2014	5	3	100%	90%
36	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр 2006-11-09 №263	2006-2012	7	1	90%	90%
37	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2007-09-12 №225	2007-2009 2010-2012 2013-2015	10	10	90%	90%
38	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр 2008-2-27 №78	2008-2012	6	6	90%	90%
<b>Хүнс, хөдөө аж ахуй</b>						
39	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр 1999-04-21 №64	1999-2010	6	4	90%	90%
40	"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" үндэсний хөтөлбөр	2005-2008 2009-2012	3	3	90%	90%

	2005-06-22 №138					
41	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр 2003-06-24 №160	2003-2008 2009-2015	3	3	90%	90%
42	"Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөр 2-р үе шат 2004-08-05 №169	2005-2008 2008-2012	5	5	90%	90%
43	"Экологийн цэвэр бүтээгдэхүүн" үндэсний хөтөлбөр 2006-03-22 №50	2006-2008 2009-2015	4	4	90%	90%
44	Малын чанар сайжруулах үндэсний хөтөлбөр 2006-04-26 №93	2006-2008 2008-2012 2012-2015	4	4	90%	90%
45	Малын тэжээл үндэсний хөтөлбөр 2007-11-07 №283	2008-2011 2012-2015	4	4	90%	70%
46	"Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр 2008-02-27 №70	2008-2010	5	3	90%	90%
47	"Агропарк" төсөл 2008-04-09 №136	2008 оны 4-7 сар	2	2	90%	90%
48	Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр 2009-02-04 №32	2009-2012 2013-2016	4	4	90%	90%
49	"Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2" 2009-06-10 №173	2009-2013 2013-2017	5	4	90%	50%
<b>Аж үйлдвэр</b>						
50	Ноос дэд хөтөлбөр 2001-02-11 №26	2001-2002 2003-2004 2005-2010	4	1	90%	70%
51	Арьс шир дэд хөтөлбөр 2001-05-23 №114	2001-2003 2004-2006 2007-2010	5	2	70%	70%
52	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр 2003 №207	2003-2015	4	4	90%	90%
53	"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр" 2005-04-01 №64	2005-2015 2009-2010	4	3	90%	70%
54	Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр 2006-10-11 №246	2006-2015 2010-2015	3	3	90%	90%
55	Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр 2008-07-09 №288	2008-2016	4	4	90%	90%
56	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр 2009-09-30 №299	2009-2016	6	6	100%	70%
57	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр	2010-2012	4	4	-	-

	2009-12-23 №371					
<b>Уул уурхай</b>						
58	Бичил Уурхайг 2015он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр 2008-02-27 №71	2008-2011 2011-2015	3	3	90%	70%
<b>Барилга</b>						
59	"40000 орон сууц" хөтөлбөр/төлөвлөгөө/ 2005-06-27 №144	2005-2010	1	1	90%	70%
60	Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр 2008-03-05 №84	2008-2010 2011-2015	3	3	90%	90%
<b>Байгаль орчины салбар</b>						
61	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах ҮХ 1999-02-10 №25	1999-2000 2001-2005 2006-2015	4	4	90%	70%
62	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр 1999-03-24 №50	1999-2000 2001-2003 2003-2005 2005-2010	7	7	70%	70%
63	Чанарын болон БО-ы удирдлага менежментийг дэмжих тухай 2002-07-08 №146	2002-2006 2007-2011 2012-2016	4	4	90%	70%
64	"Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай" ҮХ 2006-05-03 №99	2007-2010 2011-2020	6	4	90%	70%
65	Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр 2006-12-20 №309	2007-2008 2008-2010	5	5	90%	70%
<b>Газар</b>						
66	Тусгай хамгаалалттай газар нутгийн ҮХ 1998	1998-2005 2005-2015	2	2	100%	90%
67	"Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр" 27.05.2009 №157	2009-2014 2015-2020	4	4	90%	50%
<b>Агаар</b>						
68	Агаарыг хамгаалах хөтөлбөр 1999-05-25 №82	1999-2004 2005-2010	4	3	90%	90%
69	Уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр 2000-07-20 №120	2005-2010 2011-2015	6	5	90%	70%
<b>Ус</b>						
70	Усны ҮХ 1999-03-10 №43	2001-2005 2006-2010	5	5	90%	90%
71	Ус цаг уур, орчны шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр 2002 №182	2002-2015	4	4	90%	90%

<b>Ургамал</b>						
72	Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр 2002-05-29 №105	2002-2005 2006-2010	6	6	90%	90%
73	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2003-06-04 №141	2003-2007 2008-2012	4	4	90%	70%
74	Ойн тухай үндэсний хөтөлбөр 2001-10-31 №248	2006-2010 2011-2015	5	5	90%	70%
75	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр 2005 №44	2005-2015 2015-2025 2025-2035	6	5	90%	90%
<b>Амьтан</b>						
76	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр 2008 №267	2008-2015	4	4	90%	90%
<b>Төрийн удирдлага</b>						
77	Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр 1999-06-16 №96	1999-2015	9	9	90%	90%
78	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 2008-01-09 №7	2008-2015	3	3	90%	50%
79	Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр	2009-2012	5	5	30%	30%
<b>Дүн</b>					86,0%	79,6%

## ***Хөрөнгийн эх үүсвэргүйгээс хэрэгжихгүй байгаа буюу хэрэгжилт нь удааширч байгаа үндэсний хөтөлбөрүүдийн жагсаалт***

1. МУ-ын ШУ, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх ҮХ
2. Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр
3. Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр
4. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр
5. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр
6. Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр
7. "Экологийн цэвэр бүтээгдэхүүн" үндэсний хөтөлбөр
8. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
9. Ноос дэд хөтөлбөр
10. Арьс шир дэд хөтөлбөр
11. Бичил Уурхайг 2015он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр
12. Чанарын болон БО-ы удирдлага менежментийг дэмжих тухай
13. "Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай" ҮХ
14. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр
15. "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"
16. Агаарыг хамгаалах хөтөлбөр
17. Уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр
18. Усны үндэсний хөтөлбөр
19. Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр
20. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр
21. Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖИЛЛАГААНД ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛСАН ТОВЧ ДҮН**

№	Үүнээс	Үүнээс							
		Хөтөлбөр				Төсөл			
	Хөтөлбөр, төслийн нэр	Нийт зарцуулах хөрөнгө	Тухайн жилд төлөвлөсөн хөрөнгө	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Хөтөлбөр хэрэгжэнээс хойш зарцуулсан хөрөнгө	Нийт зарцуулах хөрөнгө	Тухайн жилд төлөвлөсөн хөрөнгө	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Төсөл хэрэгсэнээс хойш зарцуулсан хөрөнгө
<b>Боловсрол</b>									
1	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр		11,250,0	1,011,5	9,855,480				
2	Зайны сургалтын үндэсний хөтөлбөр				14,747,5	5200,0	5200,0	2600,0	5200,0
3	СӨБ болон Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр								
4	Англи хэлний боловсролын ҮХ								
5	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2								
6	МУ-ын ШУ, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх ҮХ								
<b>Соёл</b>									
7	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр								
8	"Монгол хөмий" ҮХ	6,900,0	500,0	400,0	900,0				
9	"Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалах, сэргээн засварлах" хөтөлбөр	12,500,0	500,0	500,0	2,500,0				
10	" Морин хуур, уртын дуу" ҮХ	3,900,0	1,000,0	1,000,0	650,0				
11	Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөр	2,500,0	1,500,0	1,500,0	1,500,0				
<b>Эрүүл мэнд</b>									
12	Эрүүл мэндийн технологийг сайжруулах ҮХ		12,500,0						

13	Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх хөтөлбөр								
14	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр								
15	Нөхөн үржэхүйн эрүүл мэнд ҮХ			7,100,0	7,100,0				
16	Халдварт өвчинтэй тэмцэх ҮХ			2,638,825	2,638,825				
17	Рашаан сувиллыг хөгжүүлэх ҮХ			162,0	162,0				
18	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах ҮХ			3,667,180	3,677,180				
19	"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" 3 хөтөлбөр								
20	Амны хөндийн эрүүл мэнд ҮХ			468,5	468,5				
21	Орчны Эрүүл мэнд ҮХ								
22	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр								
23	Сэтгэцийн эрүүл мэнд ҮХ-2								
<b>Нийгмийн халамж</b>									
24	Өсвөр үе, хүүхэд залуучуудыг дэмжих үндэсний хөтөлбөр	10,000,0	2,000,0	800,0	3,800,0				
25	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр								
26	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр	6,820,0	6,820,0	6820,0	6820,0	2000,0	2000,0	2000,0	2000,0
27	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	15,000,0	3,000,0	1,400,0	5,600,0				
<b>Хөдөлмөр</b>									
28	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр	299020,0	299020,0	309095,0					
29	Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр	1500,0			1500,0				
<b>Хууль зүй</b>									
30	Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр	550,0	250,0	100,0	100,0				
31	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	500,0	500,0	300,0	300,0				
32	Монгол Улсад Хүний эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр	110,0	50,0	50,0	50,0				

33	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр	2,0470,0	2,0470,1	15200,0	33200,0				
34	Төрийн архив, албан хэрэг хөтөлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр	2,000,0	750,0	750,0	750,0				
35	Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр	205,0	205,0	110,0	110,0				
36	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр	2040,0	1920,0	1920,0	2560,0				
37	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр	200,0	200,0	30,0	30,0				
38	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр								
<b>Хүнс, хөдөө аж ахуй</b>									
39	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	8,000,0	7,500,0						
40	"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" үндэсний хөтөлбөр		3,000,0						
41	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	8,400,0	7,500,0		8,400,0				
42	"Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөр 2-р үе шат	11,200,0	21,000,00	800,0	5,000,0				
43	"Экологийн цэвэр бүтээгдэхүүн" үндэсний хөтөлбөр								
44	Малын чанар сайжруулах үндэсний хөтөлбөр	12,540,	16,500,0	6,300,0	12,540,0				
45	Малын тэжээл үндэсний хөтөлбөр	16,000,0	42,000,0	16,000,0	16,000,0				
46	"Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр	20,000,0	15,000,0						
47	"Агропарк" төсөл					1,500,0	1,500,0	1,500,0	1,500,0
48	Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр		500,0	500,0					
49	"Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2"		3,000,0	3,000,0					
<b>Аж үйлдвэр</b>									
50	Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр								
51	Ноос дэд хөтөлбөр								
52	Арьс шир дэд хөтөлбөр								

53	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	120,000,0	120,000,0	120,000,0	120,000,0				
54	"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"	763,000,0	763,000,0	763,000,0	763,000,0				
55	Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр	120,000,0	120,000,0	120,000,0	120,000,0				
56	Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр								
57	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр	400,000,0	400,000,0	400,000,0	400,000,0				
<b>Уул уурхай</b>									
58	Бичил Уурхайг 2015он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр								
<b>Барилга</b>									
59	"40000 орон сууц" хөтөлбөр/төлөвлөгөө/	577,000,0	498,000,0	498,000,0	498,000,0				
60	Төрийн албан хаагчдын орон сууц дэд хөтөлбөр	42,000,0	42,000,0	42,000,0	42,000,0				
61	Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр	610,000,0	20,000,0	20,000,0	20,000,0				
<b>Байгаль орчины салбар</b>									
62	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах ҮХ	1,200,0	1,200,0	1,200,0	1,200,0				
63	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр	15,500,0	15,500,0	15,500,0	15,500,0				
64	Чанарын болон БО-ы удирдлага менежментийг дэмжих тухай								
65	"Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай" ҮХ								
66	Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр								
<b>Газар</b>									
67	Тусгай хамгаалалттай газар нутгийн ҮХ								
68	"Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"								
<b>Агаар</b>									
69	Агаарыг хамгаалах хөтөлбөр								
70	Уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр								
<b>Ус</b>									
71	Усны ҮХ								

72	Ус цаг уур, орчны шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр								
<b>Ургамал</b>									
73	Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр						150,0	150,0	150,0
74	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр								
75	Ойн тухай үндэсний хөтөлбөр		21,000,0	21,000,0	11,700,0				
76	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр		4,000,0	4,000,0	5,328,0				
<b>Амьтан</b>									
77	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр								
<b>Төрийн удирдлага</b>									
78	Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр	30,000,0	5,000,0	5,000,0	30,000,0				
79	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	117,997,342	42,602,342	42,602,343	117,997,342	7200,0			
<b>Нийт дүн</b>		304125,0	304395,0	338005,5	47600,5		7350,0	4750,0	7350,0

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**